



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 08 сарын 28 өдөр

Дугаар А/239

Сүхбаатар сум

Элсэлтийн ажил зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5"а", Мэргэжлийн боловсрол сургалтын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3, 15.4, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.4.9, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.6.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн судалгаа, ажил олгогчдын захиалгыг үндэслэн Сүхбаатар, Шаамар сумын Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, Мандал сумын Политехникумийн 2020-2021 оны хичээлийн жилд оюутан суралцагч элсүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг 1 дүгээр хавсралт, мэргэжлийн чиглэл, хяналтын тоо, хуваарийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Батлагдсан мэргэжлийн чиглэл, хяналтын тоонд багтаан элсэлтийн ажлыг зохион байгуулахыг ажлын хэсгийн ахлагч, аймгийн Нийгмийн бодлогын асуудал хариуцсан орлогч дарга, Ерөнхий боловсролын сургуулийн захирлууд, Мэргэжлийн болон техникийн сургуулийн захирлуудад үүрэг болгосугай.

3. Элсэлтийн ажлын зохион байгуулалт, үр дүнгийн талаар 2020 оны 09 дүгээр сарын 01-ний дотор танилцуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, аймгийн Нийгмийн бодлогын асуудал хариуцсан орлогч даргад даалгасугай.


4. Энэ захирамж гарсантай холбогдуулан 2019 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн А/188 тоот захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ

Аймгийн Засаг даргын
2020 оны 08 сарын 28 -ны өдрийн
А/239 дүгээр захирамжийн хавсралт



Элсэлтийн ажил зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч:

- Аймгийн Нийгмийн бодлогын асуудал хариуцсан орлогч дарга

Нарийн бичгийн дарга

- Сүхбаатар сумын Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн захирал

Гишүүд

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
- Аймгийн Боловсрол соёл, урлагийн газрын дарга
- Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга
- Мандал сумын Политехникумын захирал
- Шаамар сумын Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн захирал
- Сумдын Засаг дарга нар
- Ерөнхий боловсролын сургуулиудын захирлууд